



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2023 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 511

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,  
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 2 нэрийн, нийт 273,750,120.00 (хоёр зуун далан гурван сая долоон зуун тавин мянга нэг зуун хорин) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, нийт үнийг 82,125,036.00 (наян хоёр сая нэг зуун хорин таван мянга гучин зургаан) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэхэд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хөрөнгийн ашиглах, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,  
АШИГЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2023 оны 10 дугаар сарын 19-ны өдрийн  
 ..... дугаар тогтоолын хавсралт



Эрчим хүчний яамны үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, үлдэх өртөггүй ашиглалтын хугацааг сунгаж,  
 үнийг шинэчлэн тогтоох хөрөнгийн жагсаалт

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Шинэчлэн тогтоосон хугацаа /жилээр/	Шинэчлэн тогтоосон үнэ (төгрөг)
1	Хьюндай старекс /Hyundai, Starex/ маркийн, 01-63 УНУ улсын дугаар, KMJWA37RACU519500 арлын дугаар	2016-12-31	1	ш	48,750,120.00	48,750,120.00	2	14,625,036.00
2	Тоёота Ландкрузер-200 /Toyota, Land Cruiser-200/ маркийн, 06-95 УБР улсын дугаар, JTMCV02J504204340 арлын дугаар	2016-11-24	1	ш	225,000,000.00	225,000,000.00	2	67,500,000.00
			2		273,750,120.00	273,750,120.00		82,125,036.00
	Нийт дүн		(хоёр)		(хоёр зуун далан гурван сая долоон зуун тавин мянга нэг зуун хорь)			(наян хоёр сая нэг зуун хорин таван мянга гучин зургаа)